

Монголын авто мастеруудын холбоо, "Петротрак" ХХК-иас аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран манай аймгийн Чойр хотноо "Petrovis super cup, Choir-2015" авто машины бартаат замын уралдааныг 2015 оны 01 сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Уралдаанд 52 жолооч оролцож 2.7 км урттай тойрог замд өрсөлдөж ур чадвар, эр зориг, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.



Говьсүмбэр аймгийн Сагсан бөмбөгийн "ЧОЙР ЛИГ-2015" тэмцээнийг ээлжит тоглолт 2015 оны 02 сарын 28-нд Биеийн тамир, спортын газрын спорт зааланд 12.00 цагаас амжилттай зохион байгуулж Төрмөнх даргатай УБТЗамын Чойр зангилааны "АРСЛАНГУУД" баг, Мөнхзул дасгалжуулагчтай "Шивээ-Овоо" ХК-ий багуудын тоглолт амжилттай зохион байгуулагдаж 5 дахь ээлжийн тоглолтонд хийж 2:3 Төрмөнх даргатай УБТЗамын Чойр зангилааны " АРСГАЛГУУД" баг хожсон.



2015 оны Сагсан бөмбөгийн U-18 нас хүртэл насны улсын аварга шалгаруулах тэмцээн 01 сарын 12-18-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү тэмцээнд манай аймгийн баг тамирчид амжилттай оролцож 3-р байранд орж хүрэл медаль хүртсэн. мөн энэ үеэр Тамирчин Н.Ганпүрэв улсын шилдэг хамгаалагч, Тамирчин Б.Цасчимэг, Н.Ганпүрэв нар Улсын шигшээ багт тоглох эрх авч, азийн сурагчдын аварга шалгаруулах тэмцээнд оролцохоор болсон.



Монгол улсын U-14 насны өсвөрийн улсын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн улаанбаатар хотноо 03 сарын 22-27-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд нийт 10 аймаг, 4 дүүргийн хөвгүүдийн 2 баг, охидын 15 багийн тамирчид оролцлоо. Говьсүмбэр аймгаас оролцож охидын баг 6 тоглолт хийж U-14 насны өсвөрийн улсын аваргын хүрэл медаль хүртлээ.





Өсвөр насныханы бие бялдрыг чийрэгжүүлэх, тэдний өвлийн агаарт биеийн тамирын арга хэмжээнд өргөн хамруулах, багаар ажиллах чадварыг нь нэмэгдүүлэн хамтач хүмүүжил олгох, авъяас чадварыг нь нээн хөгжүүлэх, өвлийн спорт өвлийн олимпийг сурталчлах зэргээр зохион байгуулсан. Өдөрлөгийг 2015 оны 2 дугаар сар 11-ны өдөр амжилттай зохион байгуулж нийт төвийн 3-н сургуулийн 16 ангийн 384 гаруй сурагчид оролцлоо. Өдөрлөг нь хөлбөмбөг, хөгжилтэй буухиа, олс таталт, цасны сумо бөх зэрэг төрлүүдээр зохион байгуулсан.



Жюү Жицү бөхийн өсвөрийн 2015 оны улсын аварга шалгаруулах тэмцээнд манай тамирчид амжилттай оролцлоо. О.Жавхланбаяр дасгалжуулагчтай оролцсон Политехник коллежийн дэргэдэх “Чойрын бүргэд” клубын баг тамирчид 1 алт, 4 хүрэл медаль хүртлээ. Охидын 48 кг-ын жинд Б.Шинэцэцэг алт, +60 кг-ын жинд Х.Уранхишиг, хөвгүүдийн 48 кг-ын жинд Б.Оргилхуяг, 64 кг-ын жинд Ш.Бумбаяр, 69 кг-ын жинд Ч.Ууганбаяр нар тус тус хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлээ.



2015 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өсвөр үе, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2015 оны 05 сарын 21-25-ны өдрүүдэд Дархан-уул аймагт амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд говьсүмбэр аймгийн баг тамирчид амжилттай оролцож Зээрэнцэг шидэлтийн F-33,34 ангилалын төрөлд Д.Бадамханд мөнгөн медаль хүртлээ. мөн Зээрэнцэг шидэлтийн F-37 ангилалын төрөлд А.Болорцэцэг, Бөөрөнцөг шидэлтийн F-37 ангилалын төрөлд н.Ганбилэг, Өсвөрийн үеийн 800м гүйлтэнд Э.Цэрэн нар тус бүр 4-р байрт шалгарлаа.





Хөдөө орон нутагт жүдо бөхийн спортыг хүүхэд багачуудын дунд өргөн дэлгэр хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, тэдний авъяас билгийг нээх зорилгоор Аймгийн аварга шалгаруулах нээлттэй өсвөрийн жүдо бөхийн тэмцээн 02 сарын 13-нд Шивээговь суманд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 1-р байр шивээговь сумын хаялга спорт клуб, 2-р байранд Бор-Өндөр сумын баг тамирчид, 3-р байранд Аймгийн БТСГ-ын баг тамирчид орлоо.



Дэлхийн зөн ОУБ “Хүүхдийн хамгаалал хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулагдсан “KHUCH CUP-2015” Жүдо бөхийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 04 сарын 02-05-ны өдрүүдэд Улаабаатар хотын Спортын төв ордонд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд нийт 30 байгууллагын багийн 320 гаруй өсвөрийн тамирчид оролцлоо. Тэмцээнд Говьсүмбэр аймгаас 1 багш, 10 тамирчид оролцож Охид: 48 кг Б.Шинэцэцэг хүрэл, Хүрэл медалийн төлөө 2 тамирчин өрсөлдлөө.



Билгийн тооллын ХҮII жарны “Согтууруулагч” хэмээх модон хонь жилийн сар шинийн баярт зориулсан улс, аймгийн алдар цолтой хүчит бөхийн барилдаанд 2015 оны 02 сарын 14-ний өдөр Говьсүмбэр аймгийн төв Чойр хотноо амжилттай болж өндөрлөлөө. Барилдаанд аймгийн арслан Д.Түмэнжаргал, Т.Пүрэвсүрэн, Б.Гончигтавхай тэргүүнтэй хүчит 32 бөх уран мэх, ухаан бодол, бяр хүчийг үзэн барилдлаа..





Аймгийн спортын салбар холбоодын тэргүүн болон дасгалжуулагч багш нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг 2015 оны 3-р сарын 4-нд Сүмбэр сумын засаг даргын тамгын газрын хурлын танхимд зохион байгууллаа. Сургалтанд Аймгийн засаг даргын орлогч Д.Сүрэнжав, НХХ-ын биеийн тамир, спорт хариуцсан мэргэжилтэн Г.Анхбаатар нар оролцлоо. Сургалтанд аймгийн 16 спортын салбар холбоод оролцсон.



Уул уурхай жишиг Политехник коллежийн багш ажилчдын дунд зохион байгуулагдсан "Спортын бага наадам" 5 төрлөөр явагдлаа. Тэмцээн 2015 оны 03 сарын 09,10-ны өдрүүдэд явагдаж, дүнгээ гаргасан.





Говьсүмбэр аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимаас зохион байгуулж буй Үндэсний хэлэлцүүлгийн үеэр Биеийн тамир, спортын зааланд волейболын тэмцээнд салбар салбарын бизнес эрхлэгчид, банк, ОУБ-ын ажилтан, төрийн албан хаагчдыг дунд 03 сарын 22-нд амжилттай зохион байгууллаа. нийт 42 оролцогч оролцсон.



Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулдаг арилжаа банкуудын дундах гар бөмбөгийн тэмцээн 03 сарын 22-нд Политехникийн коллежийн спортын зааланд спортын 3 төрлөөр амжилттай зохион байгуулагдсан. Тэмцээн Хаан банк, Төрийн банк, Хас банк, Капитал банкын 50 гаруй албан хаагчид оролцсон.





Ширээний теннисний өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 03 сарын 07-нд биеийн тамир, спортын зааланд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 12 хүртэл нас, 13-15 нас, 16-18 насны ангилалаар ганцаарчилсан, дан хос, холимог хос гэсэн 3 төрлөөр зохион байгуулагдсан.



Шатрын өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 03 сарын 15-нд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 12 хүртэл нас, 9-10 нас, 11-12 нас, 13-14 нас, 15-16 нас 17-18 насны ангилалаар амжилттай зохион байгуулагдсан. Төрөл тус бүрээр амжилттай оролцсон тамирчдыг эхний 3-р байр эзлүүлэн өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Шалгарсан баг тамирчдыг улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцоно.





Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 94 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-т зориулсан барилдаан Говьсүмбэр аймгийн Биеийн тамир, спортын газрын зааланд амжилттай болж өндөрлөлөө




Аймгийн “Боржигон сүлд” ТББ, Аймгийн үндэсний бөхийн холбоо хамтран сар бүр уламжлал болгон зохион байгуулж буй Үндэсний бөхийн барилдааныг 03 сарын 21-нд амжилттай зохион байгууллаа. Барилдаанд Улс, аймгийн цолтой 32 бөх барилдсанаас Улсын арслан Д.Азжаргал түрүүлж, Аймгийн арслан Т.Пүрэвсүрэн үзүүрлэж, Аймгийн арслан Д.Түмэнжаргал, Аймгийн арслан Б.Гончигтайхай нар шөвгөрсөн. Мөн 4,5 настай хүүхдийн үндэсний бөхийн барилдааныг амжилттай зохион байгууллаа. барилдаанд нийт 29 хүүхэд барилдсанаас 1-р байранд Т.Аз-Эрдэнэ, 2-р байр Г.Олзбаяр, 3-р байр Г.Эрхэмбаяр нар шалгарсан. Барилдааны шагналыг “Болд төмөр ерөө гол” ХХК ивээн тэтгэлээ.





2015 оны 4 дүгээр сар 20-ны ажлын хурал дээр байгууллагын ажилтан, албан хаагч нарт ЗАА-ын дарга, нягтлан бодогч Б.Анхтуяа Шилэн дансны хууль болон 1-р улирлын төсөв, санхүүгийн мэдээллээр сургалт зохион байгуулсан



Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аяны хүрээнд байгууллагынхаа ажилтан албан хаагчдад 2 ширхэг вакуус, 1 ширхэг үрлэн витамин тараасан.



2015 оны 4 дүгээр сарын 3-5 хооронд өөрсдийн хүч бололцоог ашиглан Спорт заалны дээд талын ханыг хусаж цэвэрлэн эмүльс татаж засварын ажил хийгдсэн.



Аймгийн Засаг даргын 2014 оны 05 сарын 01-ны А/135 дугаар захирамж, “Мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд Биеийн тамир, спортын газрын албан, ажилчид бор хуайс 32 ,улиас 10 ширхэг модыг тариад байна. тарьсан модын хооронд зүлэг 8 кг тарьсан. Албан хаагч, ажилчдаас 5000 төгрөг гаргаж 18 мод худалдан авч тарьсан.





Самбо бөхийн насанд хүрэгчдийн дэлхийн аварга, Монгол улсын 21 удаагийн аварга Б.Ариун-Эрдэнийн нэрэмжит “Монголын хүүхдийн спортын 5-р наадам”-ын хүрээнд зохион байгуулагдаж байгаа 2015 оны “Өсвөрийн самбочдын улсын аварга шалгаруулах тэмцээн Булган аймагт 2015 оны 04 сарын 9-12-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж өндөрлөлөө.



Шивээговь суманд 05 сарын 18-нд болсон Аймгийн “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгт Биеийн тамир, спортын газраас 4 хүний бүрэлдэхүүнтэй оролцож 12 иргэний биеийн индексийг тодорхойлж, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүлж 56 ширхэг гарын авлага тараасан.





Аймгийн засаг даргын нэрэмжит “Спортын бага наадам”-ыг 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулж нийт аж ахуй нэгж, албан байгууллагын 27 багийн 972 тамирчид оролцсон.





Өсвөр үеийн аварга шалгаруулах даамны тэмцээн 2015 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 1-р сургууль дээр зохион байгуулагдлаа. Тэмцээнд Ерөнхий боловсролын 4 сургуулийн нийт 40 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин оролцлоо. Тэмцээнд 5-7нас, 8-10нас, 11-13нас, 14-16 насны ангилалаар зохион байгуулж, нас бүрийн ангилалаар эхний байр эзлүүлж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнасан



Өсвөр үеийн аварга шалгаруулах хөнгөн атлетикийн тэмцээн 2015 оны 04 сарын 25-ны өдөр хөнгөн атлетикийн талбайд зохион байгуулагдлаа. Тэмцээнд Ерөнхий боловсролын 4 сургуулийн нийт 60 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин оролцлоо. Тэмцээн нь спортын 9 төрлөөр эхний 3 байр эзлүүлж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнасан.



2015 оны Жүдо бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн 04 сарын 22-26-ны өдрүүдэд Увс аймгийн Спортын төв ордонд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд нийт 21 аймаг, 6 дүүрэг, байгууллагын 40 багийн 600 гаруй өсвөрийн тамирчид оролцлоо. Тэмцээнд Говьсүмбэр аймгаас 1 багш, 5 тамирчид оролцож Охид: 48 кг Б.Шинэцэцэг хүрэл, Шигшээ барилдаанд 1 тамирчин өрсөлдөж хүүхдийн спортын их наадамд оролцох эрх авлаа.



МХБХолбоо, Японы ХБХолбоо хамтран зохион байгуулсан футзалын өсвөр үеийн аварга шалгаруулах “ШИДЭТ БӨМБӨГ-2015” тэмцээний шигшээ тэмцээн 2015 оны 4 дүгээр сарын 1-6 хооронд Улаанбаатар хотноо футзалын ордонд зохион байгуулагдсан., U-14 ангилалд О.Бат-Оргил ахлагчтай баг тамирчид шувтаргын тоглолтонд шалгаран мөнгөн медаль хүртсэн амжилт үзүүлсэн.





Усан спорт , сургалтын төв, Аймгийн татварын хэлтэстэй хамтран 05 сарын 07-нд “Говийн загас” өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр усанд сэлэлтийн 2 төрлийг зохионг байгуулж нийт 40 гаруй иргэд оролцсон



Чойр зангилааны Ахмадын хорооны хэсгүүдийн дунд хөдөлгөөний хомсдол, эрүүл мэндийг сахин хамгаалах үүднээс хөдөлгөөнт дасгал хийж эхэлсэн 6 жилийн ойг тохиолдуулан “Хөдөлгөөн Үрдүн” сэдэвт дасгалын тэмцээн 2015.05.24 Төмөр засын Соёлын төвд зохион байгуулагдсан.

Тус тэмцээнд Чойр зангилааны Хөдөлгөөн, Үйлчилгээ гэсэн багуудын нийт 38 ахмад оролцсон. Тэмцээн Аеробик, Жавхаа, Хийн дасгал гэсэн 3 төрлөөр зохиогдсон.



Узбекистан улсын нийслэл Ташкент хотноо болж буй даамын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд манай аймгийн харъяат, Сүмбэр сумын 2-р сургуулийн сурагч Сүхбаатарын Сарантуяа амжилттай оролцож үндсэн төрөлд 1 мөнгө, туслах төрөлд 2 хүрэл медаль хүртлээ. Тэрээр охидын 17 насны ангилалд 100 буудалт даамын үндсэн төрөлд мөнгөн медаль, Rapid буюу түргэн тоглолтын төрөл, Blitz төрөлд тус бүр хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн.





Идэрчүүдийн Улсын аврага шалгаруулах тэмцээний Зүүн бүсийн аврага шалгаруулах тэмцээн нь 2015 оны 3 дугаар сарын 27-оос 3 дугаар сарын 30-ны хооронд Хэнтий амгийн Чингис хотод зохион байгуулагдсан. Тэмцээнд Говьсүмбэр аймгийн охид, хөвгүүдийн шигшээ багийхан амжилттай оролцоод ирлээ. Үүнд:  
 Охидийн шигшээ баг 2 хожил, 2 хожигдолтойгоор 3-р байр эзэлж Улсын аврага шалгаруулах тэмцээнд оролцох эрх авсан.




Жүдо бөхийн өсвөр үеийн 2015 оны улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдыг шалгаруулах зүүн бүсийн тэмцээн 03 сарын 26-29-ны өдрүүдэд Дорноговь аймагт амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд Говьсүмбэр аймгаас 2 багш, 32 тамирчид оролцож Охид: 40кгЭ.Ариунжаргалалт, 48 кг Б.Шинэцэцэг алт, 63 кг жинд М.Мөнгөнцэцэг хүрэл,+70 кг жинд Б.Цоож хүрэл, хөвгүүдийн 38 кг жинд Б.Баярням мөнгө, 66кг жинд Г.Энх-амгалан мөнгө, 46 кг жинд Б.Энхбаатар хүрэл медаль хүртсэн.  
 Хүрэл медалийн төлөө 4 тамирчин өрсөлдөж улсын аварга шалгаруулах тэмцээн оролцох эрхээ авлаа.





Хэнтий аймагт болсон өсвөрийн сагсан бөмбөгийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн охидын баг алтан медаль хүртлээ. Мөн Н.Ганпүрэв шилдэг тамирчинаар шалгарлаа.



Футзалын зүүн бүсийн өсвөр үеийн аварга шалгаруулах “ШИДЭТ БӨМБӨГ-2015” тэмцээний тэмцээнд Говьсүмбэр аймгийн баг тамирчид алтан медаль хүртсэн.



Дорнод аймагт болсон өсвөрийн хөлбөмбөгийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд U15 насны ангилалд Говьсүмбэр аймгийн баг алтан медаль хүртлээ.

